БАТЛАВ:
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.СОЁЛМАА

2023 оны 11 дүгээр сарын 22

# “Дэвшилтэт технологит суурилан Багшийн хөгжлийг дэмжье ” төслийн ажлын даалгавар

2023 он

## ТОВЬЁГ

**1.Төслийн ерөнхий мэдээлэл**

**2.Танилцуулга**

**3.Төслийн үндэслэл**

**4.Төслийн зорилго**

**5.Төслийн зорилт**

**6.Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

**7.Төслийн төсөв**

**8.Төслийн үр дүн**

**9.Төслийн үргэлжлэх хугацаа. Төслийн хяналт, үнэлгээ**

**Төслийн нэр:** "Дэвшилтэт технологит суурилан Багшийн хөгжлийг дэмжье" төсөл

**Төсөл хэрэгжүүлэх байгууллага:** Сэлэнгэ аймгийн Орхон сумын Орхон сургууль

**Төсөл боловсруулсан:** Орхон сургуулийн сургалтын менежер Б.Маралчимэг утас 99330272, мэдээллийн технологийн багш Б.Ганчимэг утас 99746372

**Төсөл хэрэгжих газар:** Сэлэнгэ аймгийн Орхон сумын I багийн Орхон сургууль

**Хамтран ажиллах газар:** Сургалтын Хэрэгслийн Худалдаа 98095485

**Төслийн хэрэгжих хугацаа:** 2023-2024 оны хичээлийн жил

**Төслийн нийт зардал:** 70 000 0000 төгрөг

**Төслийг эхлэх хугацаа:** 2023 он

**Холбоо барих хүний нэр:** Орхон ЕБС-ийн захирал Б. Соёлмаа, Б.Маралчимэг утас 99330272

**Төслийн үндэслэл:**

Боловсролын салбарын үйлчилгээ, сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж буй өнөө үед багш ажлын байран дээр тасралтгүй хөгжих, мэргэжлийн хөгжлийг дэмжсэн дэвшилтэт технологит суурилан багшийн хөгжлийн төвийн хэрэгцээ нэн тэргүүний асуудал болж байна.

Тус хичээлийн байрны сургалтын орчин, танхим, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материал орчин үеийн сургалтын шаардлага хангахгүй байна. Багш нараас судалгаа авч үзэхэд судалгаанд оролцогсдын 80% нь сургалтын тоног төхөөрөмж техник хэрэгсэл нь шаардлага хангадаггүй гэсэн санал өгсөн байна. Бусад улс орнуудын сургуулиудийн хөгжилд нийцсэн багшийн хөгжлийн төвийг засаж тохижуулснаар багш ажлын байрандаа тасралтгүй хөгжиж, сургалтын таатай орчин бүрдэж сургалтын чанар сайжрах, суралцагчдын анхаарал төвлөрөлт нь эрс нэмэгдэж сурах идэвх оролдлого нь нэмэгддэг нь судалгааны үр дүнгээр батлагдсан. Иймд олон улсын стандартад нийцсэн "БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ"-ийг тохижуулах шаардлагатай байна.

**Төслийн зорилго:**

- Мэргэжлийн бүх багш нар багш хөгжлийн төвөөр дамжуулан сургалтыг чанартай, хүртээмжтэй, тэгш хүргэх боломжтой
- Багш ажлын байран дээр цахимаар болон танхимаар мэргэжил дээшлүүлэх боломжтой
- Сурлагын чанарт ахиц гаргах
- Ажлын байрны сургалтыг зохион байгуулах
- Эцэг эхийн сургалт, хүүхдийн чуулганы үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах
- Мэргэжлийн хөгжлийн бүлэг, судлагдахууны бүлгээр цахимаар хамтран ажиллаж мэргэжил дээшлүүлэх боломжтой

**Төслийн зорилт:**

- Багшийн ажиллах таатай орчинг бүрдүүлэх
- Сурагчдын хөгжилд ахиц гарах
- Суралцагчдын идэвх санаачлагыг дээшлүүлэх
- Мэргэшсэн багш нарыг бэлтгэх
- Ирээдүйдээ итгэлтэй иргэн болгон төлөвшүүлэх

**Төслийн зарчим:**

- Төслийн үйл ажиллагаа талуудын нээлттэй хамтын ажиллагаанд түшиглэнэ
- Багшийн цаг үетэйгээ нийцсэн хөгжлийг анги танхимд, сургуульд, гэр бүлд, нийтмийн орчинд дэмжинэ.
- Сургууль, багш, эцэг эх, олон нийт хүүхдийн хөгжлийг хангахад хамтран зүтгэгчид, дэмжигчид байна.

**Төсөлд оролцогч багш нарт тавигдах шаардлага:**

- Багшлах эрхтэй ба одоо багшийн ажил эрхэлж байгаа.
- Хүүхдийг хөгжүүлэх арга замыг идэвхтэй эрэлхийлдэг.
- Хамтран сурахуйн сургалтын арга, туршлага бусадтай хуваалцах ба багаар ажиллах чадвартай.
- Өөрийн явуулж буй сургалтанд үнэлгээ дүгнэлт өгч өөрийгөө хөгжүүлэх

**Төслийн багшийн ажил үүрэг:**

- Багш хүүхдийн хөгжлийг хангахад талуудын оролцоог бий болгож сургуулийн удирдлага бусад багш нар, эцэг эх, олон нийттэй хамтран ажилладаг ба хичээлээр болон хичээлийн бус цагаар хүүхдийг хөгжүүлдэг байна.
- Өөрийн сургалтын ба хүүхдийн сурах үйл ажиллагаанд зөв шударга үнэлгээ өгч, улмаар цаашдын хөгжлийг хангах алхам, үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлдэг байна.
- Төслийн багш нь мэргэжлийн ёс зүй ба харилцааны хэм хэмжээг даган биелүүлж өндөр ёс суртахууныг ямагт эрхэмлэнэ.
- Бусад багш нартай хамтран ажиллан мэдлэг, туршлагаа хуваалцах ба аливаа асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэнэ.

**Төслийн хүрээнд хийгдэх ажлууд:**

- Төслийн талуудын уулзалт
- Багш нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх сургалт судалгааны баг ажиллах
- Багш нарын дунд туршлага солилцох, уулзалт ярилцлага зохион байгуулах
- Багш нарын дунд төслийг гүйцэтгэгч байгууллага, хувь хүний нэрэмжит англи хэлний олимпиадыг сумын хэмжээнд зохион байгуулах
- Аймаг болон нэрэмжит олимпиадад бэлтгэх

**Төслийн хүрэх үр дүн:**

- Мэргэжлийн багш нар цахим сургалтыг чанартай, хүртээмжтэй, тэгш хүргэх, сурагчид үр ашгийг хүртэх
- Багш нарын туршлага солилцох, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Сургууль, багш, эцэг эх, бусад дэмжигч талуудын оролцоог хөгжүүлснээр суралцагч бүрийн хэлний мэдлэгийг дээшлүүлэх нөхцөл боломжоог бүрдүүлэх

Дэвшилтэт технологит суурилан Багшийн хөгжлийг дэмжье" төслийн ажлын даалгавар

2023.11.22

| № | Барааны нэр | Зураг | Үзүүлэлт | Тоо | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зөөврийн компьютер |  | Dell Inspiron 5620 i7-1255U 8GB 512GB SSD Backlit FHD+ FPT зөөврийн компьютер | 11 | 3339900 | 36738900 |
| 2 | Ухаалаг дэлгэц /хөлтэй/ |  | Smartify interactive Smart board 75" I3 Windows 10 pro*64 (Activated)+and roid 8.0 | 1 | 9000000 | 9000000 |
| 3 | Оффис 4 хос ширээ |  | Хос ширээ Урт-240см Өргөн-120см Өндөр-110см | 5 ш | 1385000 | 6925000 |
| 4 | Сандал |  | Түшлэгтэй гүйдэг сандал | 20 | 350000 | 7000000 |
| 5 | Онлайн хурлын заалны камер хаяг:цахим хурлын шийдэл |  | Full HD 1920*1080 PTZ 10*, 3X USB 360* эргэлт | 1 | 1600000 | 1600000 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Онлайн хурлын заалны микрофон хяг:цахим хурлийн шийдэл |  | 360 6mics<br>3w, Dynamic<br>Утасгүй<br>4000 mah 18650 | 1 | 540000 | 540000 |
| 7 | WEB камер |  | Full HD<br>1920*1080<br>PTZ<br>10*, 3X<br>USB<br>360* эргэлт | 1 | 170000 | 170000 |
| 8 | Компьютер пад |  | 30 см<br>30см | 10 | 20000 | 200000 |
| 9 | Монтаж, Даллдагч, Уртасгагч | | Сайн чанарын | | 445000 | 445000 |
| 10 | Ханын оффис шкаф |  | Урт-200см<br>Өндөр-180см<br>Өргөн-40см | 1 | 1585000 | 1585000 |
| 11 | Бичгийн шүүгээ |  | Урт-80см<br>Өндөр-180см<br>Өргөн-40см | 3 | 680000 | 2040000 |
| 12 | Цайны жижиг шүүгээ |  | Урт-100 см<br>Өндөр-80см<br>Өргөн-40см | 1 | 300000 | 300000 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13 | Шилэн самбар |  | Урт-120 см Өндөр-90 см | 2 | 350000 | 700000 |
| 14 | Пракетан шал |  | Цайвар шар өнгийн модон | $48м^2$ | 35000 | 1820000 |
| 15 | Гэрэлтүүлэг |  | Лед гэрэл | 6 | 70000 | 420000 |
| 16 | Хөшиг |  | Урт-185 см Өндөр-175 см | 3 | 175000 | 525000 |
| 17 | Уртасгагч |  | | 5 | 29100 | 145500 |
| **Нийт үнэ** | | | | | | **70000000** |

Ажлын даалгавар боловсруулсан:

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР: Б.МАРАЛЧИМЭГ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БАГШ: Б.ГАНЧИМЭГ

Хянасан: СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.СОЁЛМАА